



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/206

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Драйгер баталгаажуулах болон пестицид тодорхойлох эталон тоног төхөөрөмжийн 1 дүгээр багц буюу Согтуурлын зэрэг хэмжигч төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан “Пи Эс Си” ХХК-тай 7,890,000 (долоон сая найман зуун ерэн мянган) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга (Ц.Бүрэнтуяа)-д олгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Пи Эс Си” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Ч.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 04-ны өдрийн А/206 дугаар  
захирамжийн хавсралт



ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1.	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт